

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 06 дугаар сарын 11-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-15

1. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	6-15
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны
06 дугаар сарын 11-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 53.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 56 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Т.Аубакир, Ж.Батсуурь, Ж.Баясгалан, Ж.Ганбаатар, Ц.Даваасүрэн, П.Мөнхтулга, Ч.Номин, Г.Тэмүүлэн, Д.Үүрийнтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: М.Бадамсүрэн, Б.Түвшин.

Нэг.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүнээс өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Нэгтгэсэн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгээс гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэгтгэсэн төслийн 1, 2, 3, 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Нэгтгэсэн төслийн талаарх ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбатын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Төрөөс олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1
Татгалзсан: 16
Бүгд: 17
5.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Жавхлан, Д.Энхтүвшин нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Монгол Улсын албан татвар төлөгчийн анх удаа өмчилж, амьдран суусан орон сууцаа борлуулж олсон орлого.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.6.Татварын жилийн баталгаажсан тайлангаар 400 сая хүртэлх төгрөгийн албан татвар ноогдох орлоготой хувь хүний хүсэлтэд үндэслэн түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ноогдуулах орлогыг тодорхойлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 15
Бүгд: 18
16.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн албан татвар ноогдуулах орлогод доор дурдсан хувиар албан татвар ноогдуулна:

21.1.1.0-9 504 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувь, 120 000 000-180 000 000 төгрөг хүртэлх албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 11 049 600 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 20 049 600 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар;

21.1.2.0-9 504 000 төгрөг хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-24 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 1 хувиар, 24 000 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 144 960 төгрөг дээр 24 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувиар, 120 000 000 төгрөгөөс 180 000 000 төгрөг хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 9 744 960 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ноогдуулах орлого

олсон тохиолдолд 18 744 960 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар.

21.2.Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Жаргалсайхан, Х.Болормаа нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 83.3 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 21.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 2
Бүгд: 18
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаярын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх орлогод ногдох албан татварыг 100 хувиар хөнгөлнө.

Төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “9 504 000 хүртэлх төгрөгийн” гэснийг “тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх дүнгээр” гэж өөрчлөх.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батбаяр үг хэлж, гаргасан саналаа татаж авав.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 25.1.4 дэх заалтын “21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 26.1.5 дахь заалтын “21.2.2” гэснийг, 26.1.6 дахь заалтын “21.2.3” гэснийг “21.1” гэж, 25.1.6 дахь заалтын “21.2.5” гэснийг “21.2” гэж”, гэснийг, мөн зүйлийн “26.1.1” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж” гэснийг, “02 дугаар сарын 15-ны өдрийн” гэснийг “03 дугаар сарын 05-ны өдрийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 3
Бүгд: 18
83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “23 дугаар зүйлийн 23.1.14 дэх хэсгийн “21.3,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг,” гэснийг хасах гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 2
Бүгд: 18
88.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн “23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 5
Бүгд: 18
72.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 43 минут үргэлжилж, 30 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Төсвийн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 53,3 хувьтай бүрдсэн тул 2026 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр нь танилцуулна.

Далайн Батбаяр, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Даваахүүгийн Пүрэвдаваа, Дашцэрэнгийн Энхтүвшин, Ренчиндоржийн Батболд, Гомбын Ганбаатар, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвжавын Сайнзориг, Жигжидийн Батжаргал, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал, Нанзадын Наранбаатар, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүд хуралдаан ирсэн байна.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Гишүүд танхимд орж ирээгүй байгаа. Ирцэд орсон гишүүд танхимд орж ирэхийг хүсье.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.26-д “1 асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн 1 төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Чойгүнсэнгийн Чимидсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Батжаргалын Цогтнаран Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Баатарын Болд Татварын ерөнхий газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ганхуягаар ахлуулан 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танилцуулна.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2026 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар, Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурал 2026 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус тус хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.26-д “1 асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн, 1 төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар хэрэв энэхүү нэгдэхийг зөвшөөрөөгүй бол тус тусад нь санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.” гэсний дагуу хууль санаачлагч Улсын Их Хурлын гишүүн Баярмаа 2026 оны 6 сарын 9-ний өдөр нэгтгэн хэлэлцэхийг дэмжиж байгаа талаарх бичигт үндэслэн Улсын ИХ Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хууль санаачлагчдын төслийг хууль зүйн техникийн дагуу нэгтгэлээ.

Ажлын хэсэг хууль санаачлагчдын өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн төсөлд туссан асуудлыг нарийвчлан судалж, холбогдох судалгаа, тооцоолол, мэдээлэл, татвар төлөгчдөөс болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналтай танилцсан бөгөөд хуулийн төсөлд туссан асуудал бүрийг нэг бүрчлэн хэлэлцэн дараах асуудлыг Байнгын хороонд танилцуулж байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан хувь хүний орлогын албан татвар ноогдуулах хувь хэмжээг 1 хувь болгох зохицуулалтыг 4-5 шатлалтай болгох буюу сарын 792 мянган төгрөг хүртэлх 0 хувиар, 792 мянган төгрөгөөс 2 сая төгрөг хүртэлх орлогод 1 хувиар албан татвар ноогдуулах хувь хэмжээг нэмэх зохицуулалтыг үе шаттай хэрэгжүүлэхээр өөрчлөн тусгах.

Мөн хууль тогтоомжид байгаа хуульд заасан журмын дагуу хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хуулийн нэр томъёог хоёрдмол утгагүй, товч тодорхойлон илэрхийлэх нийтлэг шаардлагын хүрээнд зарим саналыг томъёолсон байгаа.

Ажлын хэсэг Улсын Их Хурлын Баярмаа нарын 32 гишүүнээс өргөн мэдүүлсэн төсөл, Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан

татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгтгэн нэгтгэсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналыг бэлтгэн томьёолж та бүхэнд тараасан байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нэгтгэсэн хуулийн төслийг анхлан хэлэлцүүлэх бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүнд баярлалаа. Одоо ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Тэгэхээр хуулийн төсөл санаачлагчдаас өргөн мэдүүлсэн төслийг уншаад үзэхээр 2, 3 зүйл байгаад байгаа юм.

1 дүгээрт сарын тэр 792 мянга хүртэл төгрөгийн орлогод ноогдох татварыг чөлөөлөх тухай асуудал байгаад байгаа юм. Манай ажлын хэсгийн томьёололд болохоор татвар нь 0 байх тухай орж ирж байгаа. Энэ хооронд юу бий юу асуудал бий юу гэж. Би бол татвараа төлчхөөд чөлөөлөлт хийгдэж байгаа учраас буцах тухай ойлголт юм байна гэсэн ерөнхий томьёолол байгаад байгаа юм уу гэж хараад байгаа юм. Энэ дээр асуудал бий юу гэж.

2 дахь зүйл Засгийн газраас өргөн барьсан төсөл дотор бол тэр орон сууцтай холбоотой, үл хөдлөх борлуулахтай холбоотой юм. Орон сууц, тэрийг ер нь ямархуу байдлаар томьёолоод байгаа юм бэ. Тэгэхээр эндээс харахаар бол би 5 жил болоод л 1 орон сууц зараад л явдаг үйл явц болж л харагдах гээд байгаа юм уу гэмээр юм байгаад байгаа юм. Тэгэхээр энд хязгаар гэж бий юу. Анх удаа энэ тэр гэсэн. Энэ дээр одоо ямархуу байр суурь байна.

Н.Наранбаатар: Ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Х.Ганхуяг: Батжаргал даргын асуултад хариулъя. 1 дүгээр асуудал бол анх Засгийн газраас буцааж олгохоор хуулийн төсөл өргөн барьсан байсан. Тэрийг бол шууд мэдүүлдгээр болгож хуулийн төсөлд хэлэлцүүлэхээр бэлдсэн байгаа. Яагаад тэгж байна вэ гэхээр буцааж олгоно гэхээр дараа жилийнхээ 1, 2 дугаар сард буцааж олгох асуудал үүснэ гэсэн үг. Тэр үед бол нөгөө төсөв бүрдэлт, юу эд нар талаасаа харвал хамгийн хүнд цаг үе байдаг. Тэгэхээр тийм хэмжээний мөнгийг буцаагаад олгоно гэхээр нөгөө мөнгөгүй байдаг, янз янзын асуудлууд үүсчих болов уу гэдэг үүднээс нь бид нар бол шууд тайлан гаргахдаа саяын тэр шатлалын дагуу мэдүүлээд, татварын хөнгөлөлтөө эдлээд ингээд мэдүүлье гэж байгаа юм.

2 дугаар асуудал. Орон сууцтай холбоотой асуудал дээр бид нар зарчмын зөрүүтэй санал бэлдчихсэн байж байгаа. Одоо энэ Байнгын хороо дээр хураагдана. Энэ дээр болохоор анх удаагаа аялал жуулчлалын бус нийтийн орон сууцаа борлуулж олсон орлого гэж томьёолж, санал хураалтад бэлдсэн байгаа. Яах вэ ажлын хэсэг дээр энийг хурааж амжаагүй юм. Тэгээд тэр бол нөгөө гишүүдээрээ. Зарчмын зөрүүтэй санал гаргаж бэлдсэн байгаа.

Яагаад аялал жуулчлалын бус гэж оруулсан бэ гэхээр энэ нөгөө фатф-тай холбоотой энэ Богд ууланд баригдсан нөгөө үнэтэй, үнэтэй хаусууд тэр татварын хөнгөлөлт рүү орчих гээд байгаа юм. Тэгээд тийм учраас аялал жуулчлалын бус нийтийн орон сууц гэж томъёолоод, тэгээд анх удаагаа гэдгээр хязгаарлахгүй бол нөгөө байнгын байр аваад зардаг нөгөө үл хөдлөх хөрөнгийн агент гэх юм уу бизнесүүдэд зориулсан ийм татварын хөнгөлөлт болчих гээд байгаа юм. Тийм учраас бид нар томъёолохдоо иргэн нь өөрөө анх удаагаа авсан байх ёстой. Аялал жуулчлалын бүсэд биш шүү. Энэ бол нөгөө Богд уулыг хэлж байгаа юм. Нийтийн орон сууц байна шүү гэдгийг бас ингээд томъёолж байна гэсэн үг.

Н.Наранбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх бөгөөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төсөл 6 зүйлтэй.

Төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Асуулт асуух гишүүн байхгүй байна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналаар санал хураалт явуулна.

Санал хураалт явуулахын өмнө Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахтай холбоотой Дэгийн хуулийн холбогдох заалтыг та бүхэнд танилцуулъя. Дэгийн хуулийн 39.20-д “төслийн зүйл хэсэг тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй санал гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж, санал хураалт явуулах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна.” гэж заасан. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Одоо саналын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Би уншаадахъя.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналаар санал хураалт явуулна.

Санал хураалт явуулахын өмнө Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахтай холбоотой Дэгийн хуулийн холбогдох заалтыг та бүхэнд танилцуулъя. Дэгийн хуулийн 39.20-д “төслийн зүйл хэсэг тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй санал гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж, санал хураалт явуулах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож, тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Ажлын хэсэг байгуулсан бол

ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна.” гэж заасан. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. 2 санал ирсэн байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Төрөөс олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлого.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат.

2 дахийг нь танилцуулъя.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Монгол Улсын албан татвар төлөгчийн анх удаа өмчилж, амьдран суусан орон сууцаа борлуулж олсон орлого.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, Жавхлан, Энхтүвшин.

Эхнийхээр санал хураалт явуулчихъя. Саналын томъёоллыг түрүүн уншиж танилцуулсан.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.төрөөс олгосон хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хадгалуулсан хадгаламжийн хүүгийн орлого.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат. Санал хураалт. 5,9 хувиар дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.1.11.Монгол Улсын албан татвар төлөгчийн анх удаа өмчилж, амьдран суусан орон сууцаа борлуулж олсон орлого.”

Ажлын хэсгээс тайлбар өгөх үү. Төсөл санаачлагч.

Х.Ганхуяг: Энийг дарга аа, гишүүд ээ, дэмжих юм. Энэ нөгөө Фатф-тай холбоотой мөнгө угаалттай холбоотой заалт байгаа юм. Тэгээд энэ дээр ямар агуулга нэмэгдэх гэж байгаа вэ гэхээр Монгол Улсын албан татвар төлөгчийн анх удаагаа өмчилж, амьдран суусан аялал жуулчлалын бус нийтийн орон сууцаа борлуулж олсон орлого гэж өөрчлөн найруулахгүй бол нөгөө Богд ууланд байдаг хаус, одоо хаана ч байдаг юм хаусууд орчих гээд байгаа юм. Тэгэхээр нөгөө нийтийн орон сууц гэдгээрээ нөгөө дундаж давхарга, нөгөө байр авдаг. Үгүй ээ, харин тийм. Хаус эд нарыг оруулахгүй хасах хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй бол яг энэ хуульд орчихвол баахан хаусууд чинь татваргүй болчих гээд байгаа байхгүй юу. Хотын төвд зөндөө хаус байгаа шүү дээ. Анх удаагаа. Энэ нөгөө Фатфтай холбоотой юм. Баясаа. Фатфтай холбоотой юм. Үгүй ээ, яах вэ энэ нөгөө татвар болохоор Фатф-

ын мөнгө угаахтай, тайлбарлаж байна шүү дээ. Тийм Фатфын мөнгө угаалттай холбоотой заалт байгаа юм. Тэгээд энийг ингээд тэр хэсгийг нь оруулахгүй болохоор дараа нь мөнгө угаасан гэдэг хэргээр манайх дахиад тэр саарал жагсаалт нөгөө цагаан жагсаалт эд нар луу орчих тийм эрсдэлтэй байгаад байгаа юм. Үгүй ээ, харин үнэлгээ нь хэцүү байхгүй юу. Тэгээд хэдэн тэрбумын татвар гарч ирнэ шүү дээ.

Н.Наранбаатар: Санал хураалт явуулъя. Одоо асуулт асуух дэг байхгүй. Гишүүд ээ, дэгээ барьж явъя. Санал хураалт явуулъя. Гишүүд ээ, санал хураалт. 77,8 хувиар дэмжигдлээ.

Нэгтгэсэн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.6.Татварын жилийн баталгаажсан тайлангаар 400 сая хүртэлх төгрөгийн албан татвар ноогдох орлоготой хувь хүний хүсэлтэд үндэслэн түүний үйл ажиллагааны орлогын нийт дүнгээр албан татвар ноогдуулах орлогыг тодорхойлж болно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал. Санал хураалт. 16,7 хувиар дэмжигдсэнгүй.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу.

2 дугаар зүйл дээрээ бас зарчмын зөрүүтэй санал байна. Уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1. Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн албан татвар ноогдуулах орлогоо доор дурдсан хувиар албан татвар ноогдуулна:

21.1.1.0-9 504 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувь, 120 000 000-180 000 000 төгрөг хүртэлх албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 11 049 600 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 20 049 600 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар;

21.1.2.0-9 504 000 төгрөг хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 0 хувиар, 9 504 000-24 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 9 504 000 төгрөгөөс дээш давсан орлогод 1 хувиар, 24 000 000-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 144 960 төгрөг дээр 24 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 10 хувиар, 120 000 000 төгрөгөөс 180 000 000 төгрөг хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 9 744 960 төгрөг дээр 120 000 000

төгрөгөөс дээш давсан орлогод 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 18 744 960 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар

21.2.Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 72,2 хувиар дэмжигдлээ.

Жаргалсайхан гишүүнийг дэмжсэнээр, Болормаа гишүүнийг дэмжсэнээр протоколд авъя.

Саяын энэ санал дэмжигдсэн учраас миний унших зарчмын зөрүүтэй ирсэн саналууд бол дэмжигдээгүйд тооцогдоно. Та бүхэнд уншиж танилцуулъя.

5.Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход жилийн 120 сая төгрөг хүртэлх орлогод дараах хувиар,

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/	Албан татвар ногдуулан хувь хэмжээ /хувиар/
31 200 001-12 000 000	0
12 00 001-14 400 000	1
14 400 001-16 800 000	2
16 800 001-19 200 000	3
19 200 001-21 600 000	4
21 600 001-24 000 000	5
24 000 000-26 400 000	6
26 400 001-28 800 000	7
28 800 001-31 200 000	8
31 200 001-33 600 000	9

120 000 001-180 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 12 000 000 төгрөг дээр 120 000 000 төгрөгөөс дээш давсан тохиолдолд 15 хувиар, 180 000 000 төгрөгөөс дээш албан татвар ноогдуулах орлого олсон тохиолдолд 21 000 000 төгрөг дээр 180 000 000 төгрөгөөс дээш давсан орлогод 20 хувиар нэмж албан татвар ноогдуулна. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэбат.

6.Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 15 дугаар зүйлд заасан тухайн жилийн орлогод 5 хувиар албан татвар ноогдуулна.

21.1.1.Татвар төлөгчийн асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тооноос хамааран дараах хувь хэмжээгээр албан татвар ноогдуулна:

21.1.1а.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо 1 бол 4 хувь;
21.1.1б.асран хамгаалалт байгаа гэр бүлийн гишүүний тоо 2 бол 3 хувь;
21.1.1в.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо 3 бол 2 хувь;
21.1.1г.асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүний тоо 4 бол 1 хувь;

21.2.Асран хамгаалалтад байгаа гэр бүлийн гишүүнд арван найман нас хүрээгүй хүүхэд, өдрийн ангид суралцаж байгаа 24 нас хүртэлх хүүхэд, тэжээн тэтгэж буй өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдийг хамруулна.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал.

7.Төслийн 2 дугаар зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогод доор дурдсан хувь хэмжээгээр албан татвар ноогдуулна:

21.1.1.2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2027 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал 5 хувиар

21.1.2.2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 1 хувиар.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар. Эдгээр саналуудыг ирүүлсэн. Санал хураалт явуулахгүй.

2 дугаар зүйл дээр бас дахиад зарчмын зөрүүтэй саналууд ирсэн байна.

8.Төслийн 2 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг, 21.5 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 88,9 хувиар дэмжигдлээ.

Гишүүдээс бас ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулна. Саяын санал дэмжигдсэнтэй холбогдуулаад дараах миний унших саналууд дээр санал хураалт явуулахгүй. Дэгийн тухай хуулийн заалттай.

Төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлсон тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх орлогод ногдох албан татварыг 100 хувиар хөнгөлнө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаяр.

10.Төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “9 504 000 хүртэлх төгрөгийн” гэснийг “тухайн жилийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх дүнгээр” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Батбаяр.

11.Төслийн 2 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийг өөрчлөн найруулах:

“23.1.Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ноогдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ.

Албан татвар ногдуулах жилийн орлогын хэмжээ /төгрөгөөр/		Албан татварын хөнгөлөлтийн хэмжээ
Доод босго	Дээд босго	
-	12 000 000	1 200 000
12 000 000	24 000 000	900 000
24 000 000	36 000 000	600 000
36 000 000	48 000 000	300 000

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа.

Саяын уншсан Далайн Батбаяр гишүүний гаргасан 2 зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж хэлэх үү. Далайн Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Би энэ гаргасан зарчмын зөрүүтэй саналаа татчихъя.

Н.Наранбаатар: Дээрх санал дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн 2, 3, 4 дүгээр зүйлийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа. Танилцуулж дууслаа.

Нэгтгэсэн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийн “25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 25.1.4 дэх заалтын “21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг, 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 26.1.5 дахь заалтын “21.2.2” гэснийг, 26.1.6 дахь заалтын “21.2.3” гэснийг “21.1” гэж, 25.1.6 дахь заалтын “21.2.5” гэснийг “21.2” гэж, “гэснийг, мөн зүйлийн “26.1.1” гэснийг тус тус хасаж, мөн зүйлийн “15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж” гэснийг, “02 дугаар сарын 15-ны өдрийн” гэснийг “03 дугаар сарын 05-ны өдрийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. 83,3 хувиар дэмжигдлээ.

Энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулан дараах саналуудаар санал хураахгүй.

Төслийн 3 дугаар зүйлийн “15-ны өдрийн” гэснийг “сүүлийн өдрийн” гэж” гэснийг, “02 сарын 15-ны өдрийн” гэснийг “03 сарын 05-ны өдрийн” гэж” өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Заяабал.

Төслийн 3 дугаар зүйлийн “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь хэсгийн “21.2.4” гэснийг, 25.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, “25.1.4 дэх заалтын 21.2.2” гэснийг, 25.1.5 дахь заалтын “21.2.3” гэснийг, 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “21.2.4” гэснийг, 26.1.2 дахь заалтын “21.2.4” гэснийг 26.1.3 дахь заалтын “21.2.1” гэснийг, 26.1.5 дахь заалтын “21.2.2” гэснийг, 26.1.6 дахь заалтын “21.2.3” гэснийг “21.1” гэж, 25.1.6 дахь заалтын “21.2.5” гэснийг

“21.2” гэж,” гэснийг, 4 дүгээр зүйлийн “23 дугаар зүйлийн 23.14 дэх хэсгийн “21.3” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг, 28 дугаар зүйлийн 28.1.3 дахь хэсгийн “23.1-д зааснаас бусад” гэснийг”, 5 дугаар зүйлийн “23 дугаар зүйлийн 23.1, 23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг, 28 дугаар зүйлийн 28.1.2-ыг” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мандхай.

Нэгтгэсэн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя.

Төслийн 4 дүгээр зүйлийн “23 дугаар зүйлийн 23.1.14 дэх хэсгийн “21.3,” гэснийг, 27 дугаар зүйлийн 27.5 дахь хэсгийн “, 23.1” гэснийг,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Анхаараарай. Санал хураалт 88,9 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Нэгтгэсэн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна. Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн саналуудаар санал хураалт явуулъя.

Төслийн 5 дугаар зүйлийн “23.10, 23.16, 23.17, 25 дугаар зүйлийн 25.5-ыг,” гэснийг хасах. Санал хураалт. Саяын ажлын хэсгийн гаргасан санал хураалт 72,2 хувиар дэмжигдлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг танилцуулна.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаан дууслаа. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

16.39 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ